




20th Story

Дахин амилж дээш өргөгдсөн нь!

Risen and Ascension

Дахин амилж дээш өргөгдсөн нь!

– 20th Story –



Өгүүлэгч

Есүс Аримат хүн Иосефын булшинд оршуулагдав. Булшны үүд том чулуугаар таглаатай байсан боловч тахилчид тавгүй байлаа. Тэд хэн нэгэн Есүсийн цогцсыг хулгайлчихаж магадгүй гэж боджээ. Учир нь Есүс үхлээс дахин амилна гэж айлдсан юм. Тиймээс тэд Пилат руу очив.

Тахилчид

Захирагч минь, ертөнцийг уруу татаж байсан тэр хүн амьд байхдаа 3 дахь өдрөө өөрийгөө амилна гэж хэлснийг бид санаж байна. Тийм учраас 3 өдөр болтол булшийг бат сайн хамгаал гэж тушаал буулгана уу. Магадгүй шавь нар нь ирээд цогцсыг нь хулгайлчихаад ард түмэнд “Тэр үхэгсдээс амилсан” гэж хэлж мэднэ.

Пилат

болж байна, харуулын цэрэг гаргаж өгье, буцаж очоод сайн хамгаал.

Өгүүлэгч

Ингээд тэргүүн тахилчид Есүсийг оршуулсан Аримат хүн Иосефын булшийг лацдан харуулын цэрэг тавьж баттай хамгаалуулав.

3 дахь өдрийн өглөө болоход Есүсийн эх Мариа, Магдалын Мариа нар Есүсийн биед анхилуун үнэрт тос түрхэхээр булш руу очжээ.

Магдалын Мариа

Өө .. булшны чулууг яаж өнхөрүүлэх вэ? Чулуу их хүнд шүү дээ.

Мариа

Нээрээ ... маш том шүү дээ. Хэн нэгэн туслах байвал сайнсан.


Өгүүлэгч

Тэд ийнхүү ярилцсаар булшинд хүрч очив. Гэтэл гэнэт хүчтэй газар хөдлөлт болов. Эзэний нэг тэнгэрэлч тэнгэрээс буун ирж булшинд дөхөж очоод тэр чулууг өнхөрүүлээд дээр нь суув. Тэр тэнгэрэлчийн дүр төрх нь аянга мэт байсан бөгөөд хувцас нь цас шиг цагаан байлаа. Хамгаалж байсан хүмүүс тэнгэрэлчийг хараад айн чичирч үхсэн хүн шиг гөлөрч зогссон.

Габриел

Мариа аа, Бүү айгтун! Цовдлогдсон Есүсийг хайж буйг чинь мэдэж байна. Тэр энд байхгүй. Учир нь хэлснээрээ Тэр амилсан. Ирэгтүн. Түүний хэвтэж байсан газрыг үзэгтүн. Хурдан очиж, шавь нарт нь “Тэр үхэгсдээс амилжээ. Харагтун, Тэр та нараас түрүүнд Галил уруу явсан тул та нар тэнд Түүнийг харах болно” гэж хэл. Үзэгтүн, би та нарт хэллээ.





Магдалын Мариа	Мариа аа! Есүсийн айлдсан ёсоор болж байна!
Мариа	Тэгэлгүй яахав. Бурханы тэнгэрэлч бидэнд айлдлаа. Өнгөрсөн удаа тэнгэрэлч над дээр ирээд хэлэхдээ худал хэлээгүй. Хурдан явж шавь нарт дамжуулъя.
Өгүүлэгч	Хоёр эмэгтэй айдас болон бөөн баяртайгаар булшнаас хурдан явж энэ мэдээг Түүний шавь нарт мэдэгдэхээр гүйлээ.
Есүс	Ээж ээ, Мариа аа
Мариа	Есүс, Эзэн минь, өө миний Хүү Есүс, амилсан байх нь
Есүс	Бүү ай. Явж, ах дүүст минь Галил уруу яв гэж мэдэгд. Тэнд Намайг тэд харах болно.
Өгүүлэгч	Хоёр эмэгтэй Есүст мөргөөд цовдлогдсон Есүсийн гарыг үнслээ. Тэгээд шавь нар руу гүйлээ. Тэд шавь нар дээр очиход шавь нар нь идэж уун Есүсийг дурсан хамт цугларсан байв.
Магдалын Мариа	Хүмүүс ээ! Есүс үхлээс дахин амилсан!!
Шавь нар	Юу гэнээ? Айн??
Магдалын Мариа	Тийм ээ, бид Түүний булш руу очиход булш хоосон байсан. Ийшээ ирэх зуур Есүстэй уулзсан, юм ч ярьсан.
Петр	Мариа хурдал ... бид бүгд Есүсийн үхэлд гуниглаж байна. Бидэнд үнэхээр хэцүү явдал боловч ийм зүйлийг хүртэл ярих хэрэг байхгүй. Тэр чинь ямар ч боломжгүй.
Мариа (Есүсийн эх)	Үгүй ээ Петр, энэ үнэн. Би ч бас хамт Есүстэй уулзсан. Миний Хүү, Миний Эзэнтэй уулзсан. Булш руу очсон боловч булш хоосон байсан. Гэтэл гэнэт Эзэний тэнгэрэлч гарч ирээд Есүс амьд гэж хэлж өгсөн. Есүс та нарыг Галил руу явж гэж хэлсэн. Тэнд та нартай уулзана гэж хэлсэн. Тэгээд бид ийшээ ирэхдээ Есүстэй шууд уулзсан.
Өгүүлэгч	Шавь нар үүнийг сонсоод тэд ихэд гайхлаа. Тэд итгэхийг хүссэн боловч яаж итгэж чадах билээ? Есүсийн үхлийг тов тодорхой харсан атал дахин амилсан гэж үү? Шавь нар нь хараахан 3 дахь өдрөө дахин амилна гэсэн Есүсийн үгийг ойлгохгүй байв. Шавь нар нь хүсэмжилсэн сэтгэлээр дуулгавартай даган Есүсийн хэлсэн ёслоор Галил руу явжээ. Түүний дараа 12 дагалдагч нь хооллож байх үед Есүс тэдэнд үзэгджээ.



Есүс	Та нарт амар амгалан байх болтугай.
Шавь нар	аааааа!!!!
Өгүүлэгч	Есүс тэдэнтэй уулзахад тэд айж, Есүсийг чөтгөр гэж бодов.
Есүс	Юунд айна вэ? Миний гарыг хар, хөлийг хар. Би Есүс
Иаков	Миний миний Эзэн??
Петр	Багш аа??
Есүс	Надад хүр, Сүнсэнд мах яс байхгүй боловч та нарын харсанчлан Би бол мах, ястай. Томас аа нааш ирээд Надад хүрээд үз.
Томас	Миний ... Эзэн минь, итгэж байна.
Есүс	Харж байж итгэх үү? хараагүй ч итгэсэн нь ерөөлтэй еэ!
Өгүүлэгч	Есүс энэ үгийг хэлээд идэх зүйл байгаа эсэхийг асуулаа. Тэгээд шавь нар нь Есүст нэг загас өгөв. Есүс шавь нартаа айлдав.
Есүс	Би урьд нь та нартай хамт байхдаа хэлж байсан. Мосегийн хууль, эш үзүүлэлэг, дуулал бичээсүүдэд Намайг тэмдэглэсэн бүх зүйл заавал биелэгдэх ёстой гэж хэлсэн.
Өгүүлэгч	Тэр үед Есүс шавь нартаа Библийг ойлгуулах гэж тэдний сэтгэлийг нээн айлдсан юм.
Есүс	Ингэж бичигдсэн байдаг. “Христ зовлон туулж 3 дахь өдрөө үхэгсдээс амилах бөгөөд Түүний нэрээр уучлагдах гэмшил нь бүх үндэстэнд тараагдах болно” гэсэн. Иерусалимаас эхлэлтэй энэ бүх явдалд та нар гэрч болно. Харагтун, Би Эцгийнхээ амласныг та нар руу явуулна. Явцгаая.
Өгүүлэгч	Есүс шавь нараа Бетан хүртэл дагуулж очоод гараа өргөн тэднийг ерөөв.
Есүс	Ах дүүс минь, Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно.
Өгүүлэгч	Есүс шавь нартаа энэ үгийг айлдсаны дараа тэнгэрт өргөгдөн дээш одоод Бурханы баруун талд суусан юм. Есүсийн шавь нар Түүнд хүндэтгэн мөргөсөн бөгөөд ихэд баярлан Иерусалим руу буцаж явлаа. Тэгээд Бурханыг магтан алдаршуулан сүмд хүмүүст зааж сайнмэдээ тараацгаав.